

**АВТО, УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН 20... ОНЫ ... -Р УЛИРЛЫН  
ТЭЭВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ**

Регистрийн дугаар									
	нэр				код				
Аймаг, нийслэл									
сум, дүүрэг									
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр									
Аж ахуйн нэгж, байгууллагын төрөл									
Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэр									%

1. Сумын ЗДТГ, дүүргийн статистикийн хэлтэс нь авто, усан замын тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжээс мэдээллийг 1,4,7,10-р сарын 2-ны дотор маягтаар авч, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт цахим шуудангаар;

2. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар нь 1,4,7,10-р сарын 4-ний дотор УСХ-нд цахим шуудангаар;

3. УСХ-нд мэдээллээ шууд ирүүлдэг аж ахуйн нэгж, байгууллага 1,4,7,10-р сарын 4-ний дотор цахим шуудангаар ирүүлнэ.

**А. Үндсэн үзүүлэлт**

Үзүүлэлт		Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Гүйцэтгэл (өссөн дүнгээр)
А		Б	В	1
<b>1. Тээвэрлэсэн ачаа</b> мөр 1=мөр (2+3)=мөр [4+10+13+14+17+20+21+(23÷25)]		1	мян.т	
Үүнээс: Дотоодод		2	мян.т	
Олон улсад		3	мян.т	
Тээвэрлэсэн ачаа, ачааны нэр төрлөөр:	ХАА-н гаралтай бүтээгдэхүүн болон амьд мал, амьтад	4	мян.т	
	Үүнээс: Ноос, ноолуур	5	мян.т	
	Арьс, шир	6	мян.т	
	Амьд мал, амьтад	7	мян.т	
	Үр тарианы зүйл	8	мян.т	
	Малын тэжээл, өвс, бордоо	9	мян.т	
	Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	10	мян.т	
	Үүнээс: Хүнсний ногоо	11	мян.т	
	Мах	12	мян.т	
	Нефть, нефтийн бүтээгдэхүүн	13	мян.т	
	Нүүрс мөр 14=мөр (15+16)	14	мян.т	
	Үүнээс: дотоодод	15	мян.т	
	экспортод	16	мян.т	
	Уул уурхайн үйлдвэрийн бүтээгдэхүүн	17	мян.т	
	Үүнээс: Төмрийн хүдэр	18	мян.т	
	Цайрын баяжмал	19	мян.т	
	Хар төмөр (хаягдал, рельс г.м)	20	мян.т	
	Барилгын материал	21	мян.т	
	Үүнээс: Мод, модон материал	22	мян.т	
	Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл	23	мян.т	
	Гэр ахуйн болон өргөн хэрэглээний бараа	24	мян.т	
	Бусад	25	мян.т	
	<b>2. Ачаа эргэлт</b> мөр 26=мөр (27+28)	26	мян.т.км	
	Үүнээс: Дотоодод	27	мян.т.км	
	Олон улсад	28	мян.т.км	
<b>3. Зорчигчдын тоо</b> мөр 29=мөр (30+31)	29	мян.хүн		
Үүнээс: Дотоодод	30	мян.хүн		
Олон улсад	31	мян.хүн		
<b>4. Зорчигч эргэлт</b> мөр 32=мөр (33+34)	32	мян.хүн км		
Үүнээс: Дотоодод	33	мян.хүн км		
Олон улсад	34	мян.хүн км		
<b>5. Төлбөрт цагийн үйлчилгээ</b>	35	цаг		
<b>6. Суудлын машины төлбөрт үйлчилгээ</b>	36	км		
<b>7. Таксины төлбөрт үйлчилгээ</b>	37	км		
<b>8. Нийт ажиллагчдын тоо</b>	38	хүн		
<b>9. Тээврийн нийт орлого</b>	39	мян.төг		

**Б. Парк ашиглалт**

	Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Тухайн улиралд			Парк ашиглалтын хувь
			дансаар бэлэн байгаа	үйлчилгээнд гарсан	шинээр нэмэгдсэн	
А	Б	В	1	2	3	4 = (2 : 1)
Том оврын автобус	40	тоо				
Троллейбус	41	тоо				
Дунд оврын автобус	42	тоо				
Бага оврын автобус	43	тоо				
Такси	44	тоо				
Суудлын машин	45	тоо				
Ачааны машин	46	тоо				
Тусгай зориулалтын машин	47	тоо				
Усан замын ачаа тээврийн хэрэгсэл	48	тоо				
Усан замын зорчигч тээврийн хэрэгсэл	49	тоо				

Тамага Захирал (эзэн) .....  
Ерөнхий (ахлах) нягтлан бодогч .....  
Эдийн засагч .....



**Авто, усан замын тээврийн тээвэрлэлтийн мэдээний  
Т-1 маягтыг нөхөх заавар**

Энэ мэдээллийг гаргах анхан шатны бүртгэл нь жолоочийн замын хуудас, Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны өдөр тутмын болон техник ашиглалтын үзүүлэлтийн бүртгэл, мэдээлэл байна.

Авто, усан замын тээвэр болон тээвэр зууч, тээвэр зохицуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ нь мэдээллээ үзүүлэлтийн дагуу үнэн зөв, бүрэн нөхөж 1,4,7,10-р сарын 2-ны дотор сумын ЗДТГ, дүүргийн статистикийн хэлтэст маягтаар, Сумын ЗДТГ, дүүргийн статистикийн хэлтэс нь мэдээллийг дараах байдлаар нэгтгэн аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт цахим шуудангаар хүргүүлнэ. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээг тус бүрийн нэр, регистрээр

- Хотын дотор болон хот хоорондын тээврийн үйлчилгээг хувиараа эрхэлдэг иргэдийн мэдээг сум, дүүргийн түвшинд нэгтгэн нэг регистрээр мэдээлнэ.

Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар нь мэдээллийг ААНБ тус бүрээр болон хувиараа тээвэр эрхлэгч иргэдийн мэдээллийг аймаг, нийслэлийн түвшинд нэгтгэн нэг регистрээр ҮСХ-нд 1,4,7,10-р сарын 4-ний дотор цахим хэлбэрээр дамжуулна.

**Аж ахуйн нэгж, байгууллагын төрлийг дотор нь** бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ББН)-11; зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ЗБН)-12; хоршоо-21; хувьцаат компани (ХК)-31; хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-32; төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-40; орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (ОНӨҮГ)-50 гэж ангилан зохих кодыг тавина.

**Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэрийг дотор нь** төрийн өмчийн-11; төрийн өмчийн оролцоотой-12; төрийн хамтарсан-13; орон нутгийн өмчийн-31; орон нутгийн өмчийн оролцоотой-32; орон нутгийн хамтарсан-33; монгол улсын иргэний-21; монгол улсын иргэний хамтарсан-22; гадаад улсын-23 гэж ангилан зохих кодыг тавина. 12, 13, 32, 33 гэсэн кодоор нөхсөн бол тухайн ААН-д төрийн болон орон нутгийн өмчийн эзлэх хувь, 22 гэсэн кодоор нөхөгдсөн бол гадны улсын эзлэх хувийг нөхнө.

**Ачаа эргэлт** (мөр 26) - Ачаа эргэлтийг тооцохдоо тээвэрлэсэн ачааг тээсэн зай/км/-аар үржүүлсэн үржвэрүүдийн нийлбэрээр тодорхойлно.

**Зорчигч эргэлт** (мөр 32) - Авто, усан замын тээвэрээр зорчсон зорчигчдын тоог аялсан зай/км/-аар үржүүлсэн үржвэрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлно.

**Төлбөрт цагийн үйлчилгээ** (мөр 35) - Төлбөрт цагийн үйлчилгээнд зөвхөн цагаар төлбөрийн тооцоо хийдэг үйлчилгээг оруулна. Тайлант хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн бусдад төлбөртэйгээр үйлчилсэн нийт цагийг нөхнө.

**Суудлын машин болон таксины төлбөрт үйлчилгээ** (мөр 36,37) - Суудлын машин болон таксины төлбөрт үйлчилгээнд зөвхөн километрээр төлбөрийн тооцоо хийдэг үйлчилгээг оруулна. Тухайн аж ахуйн нэгжийн бусдад төлбөртэйгээр үйлчилсэн нийт зай/км/-г нөхнө.

**Ажиллагчид** (мөр 38) гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ. Ажиллагчдын тоог дунджаар нөхнө. Ажиллагчдын улирлын дундаж тоог гаргахдаа өдөр бүрийн ажиллагчдын (дансны) тооны нийлбэрийг тухайн сарын нийт ажилласан өдөрт хувааж сар сарын ажиллагчдын дундаж тоог гарган, нийлбэрийг сарын тоонд хуваана.

**Тээврийн нийт орлого** (мөр 39) - Ачаа, зорчигч тээврийн болон бусад орлогуудаас бүрдэнэ. Бусад орлого гэдэгт тухайн аж ахуйн нэгжийн тээврийн үйл ажиллагаатай холбогдох бусад үйл ажиллагааны орлогыг хамруулна. Тухайлбал, ачааг ачиж буулгах үйл ажиллагаанаас орсон орлого багтана.

**Парк ашиглалт** (мөр 40÷49) - Тухайн улиралд дансаар байгаа болон тээврийн үйлчилгээнд гарсан автобус, троллейбус, микроавтобус, такси, суудлын машин, ачааны машин болон тусгай зориулалтын машины дундаж тоог нөхнө. Дунджийг гаргахдаа өдөр бүрийн автомашины тооны нийлбэрийг тухайн улирлын нийт ажилласан өдөртөө харьцуулж гаргана. Дансаар бэлэн байгаа тээврийн хэрэгслээс тухайн улиралд шинээр нэмэгдсэнийг тусгайд нь гаргаж багана 3-д нөхнө.

**Том оврын автобус, троллейбусд** 16-аас дээш хүний (жолоочийн суудлаас гадна) суудалтай автомашиныг хамруулна.

**Дунд оврын автобусд** 9-16 хүний суудалтай автомашиныг хамруулна.

**Бага оврын автобусд** 8 хүртэл хүний суудалтай автомашиныг хамруулна.

**Суудлын машинд** 8 хүртэл хүний суудалтай, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашиныг хамруулна. Таксины тоог 44-р мөрөнд тусад нь нөхнө.

**Ачааны машинд** бүх жин нь 3500 кг-аас их (5000 кг-аас ихгүй даацтай чиргүүлтэй), ачаа тээвэрлэхэд зориулсан автомашиныг хамруулна.

**Тусгай зориулалтын машинд** цистерн, цемент зуурагч машин, засвар үйлчилгээний болон тусгай зориулалтаар тоноглогдсон автомашиныг хамруулна.

**Усан замын ачаа тээврийн хэрэгсэлд** усан замаар ачаа тээвэрлэхэд зориулагдсан 1 тонноос багагүй даацтай усан онгоц хамаарна. Тухайлбал, хуурай, овоолсон, шингэн ачааны чиргүүл, татлага онгоцууд гэх мэт.

**Усан замын зорчигч тээврийн хэрэгсэлд** зөвхөн зорчигч тээвэрлэхэд зориулагдсан усан онгоц, моторт завь, сал онгоц хамаарна.

Шуудан тээврийн гүйцэтгэлийг энэхүү маягтаар нөхөж ирүүлж байна.

**Үндэсний статистикийн хороо**

Утас: 263968, 261561

Цахим хаяг: mesd@nso.mn

